

## **ХУСЕЙНЫ ХЭРГИЙГ НЭЭЛТТЭЙ ШҮҮХЭЭР ШИЙДВЭРЛЭХ ХУУЛЬ ЁСНЫ АСУУДАЛД**

*Хуан Сон Гүнь\**

**С**аддам Хусейн 2003 оны 12-р сарын 13-нд өөрийн төрөлх Тикрит хотын өмнөд хэсэгт зайдуу талбайн газар доогуурхи хоргодох газраас АНУ болон Иракийн хамтарсан цагдаагийн амьдаар нь олзлох ажиллагаагаар баригдсан. Ийнхүү Иракт дайснаас 268 хоногийн дараа Америкийн цэрэг хамгийн том дайны олз, амжилтаа олсон хэрэг байв.

Өнгөрсөн 5-р сарын 1-ний өдөр АНУ-ын ерөнхийлөгч Буш дайны ажиллагаа дууссаныг албан ёсоор зарласан ч АНУ үүнээс хойш 7 сар орчим Иракийн сөрөг хүчнийхний явуулж байгаа терроризм, зэвсэгт бүлэглэлийн дайралтанд өртсөөр байгаа билээ. Энэ бүхний гол цөмд Хусейн байсан юм. Тиймээс энэ удаа Хусейныг баривчилснаар Иракийн террорист халдлага багасах байх гэж таамаглаж байгаа юм.

Гэхдээ Хусейныг амьдаар нь баривчилснаар Иракийн улс төрийн тогтвортой байдал, ард иргэдийн амгалан тайван байдлыг сэргээх, дайны дараахи сэргээн босголтыг хурдасгах, Ойрхи дорнодод энхтайвныг сахин бэхжүүлэхэд хэр хувь нэмэр оруулах эсэх нь тийм түргэн шийдэгдэх асуудал биш. Америкийн эсрэг дайныг үргэлжлүүлэн өдөөх өөр хэн нэг толгойлогч дахин гарч ирэхийг үгүйсгэх аргагүй юм. Тиймээс одоо Иракийн асуудлыг шийдэхэд хамгийн чухал даваа гэж хэлж болно.

### *Хусейныг нээлттэй шүүхээр шийдвэрлэх хууль ёсны асуудал*

Ийм нөхцөлд Хусейныг шүүн таслах нь тулгамдсан асуудал болж байгаа юм. Үүнтэй холбогдуулан Иракийн шилжилтийн засгийн эрх барих хороо 2004 оны 1-р сарын 7-нд Хусейн болон түүний туслах зэрэг одоогийн болон өмнөх дээд албан

*\* МУИС-ийн ХЗС-ийн докторант*

тушаалтан олон хүнд хүний эрхийг бүдүүлгээр зөрчсөн гэмт хэргийг шүүх нээлттэй шүүх хурал хийх хуулийн төслийг баталсан билээ.

Хусейны хэргийг шүүх нь Иракийн дайн дэгдэхээс өмнө аль хэдийн шийдэгдсэн асуудал байв. Ирак, Кувейт руу хийсэн дайралт, хэдэн арван мянган иракчуудыг хөнөөсөн, томоохон улс төрийн хэрэгтнүүдийг нууцаар алсан болон хүний эрхийг зөрчсөн, НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн 687 дугаар тогтоол заалтыг байнга зөрчсөн зэрэг нь Хусейнд тулгаж буй ялын агуулга юм. Энэ удаагийн Хусейны шүүх Ньюнберг (1945), Токио (1946), Югослав (1993), Руанда (1994), Олон улсын эрүүгийн шүүх (2002) зэрэг бусад өмнөх түүхэн шүүхээс ялгаатай юм. Тодорхой хэмжээнд Иракийн дотоодын асуудал буюу дотоодод шүүх асуудал юм. Тиймээс АНУ, Иракийн шилжилтийн засгийн газар Хусейныг яллан шийтгэхэд хэдэн зүйлд анхаарах хэрэгтэй болж байна.

Үүнд юун түрүүн Хусейны шүүх Европ маягийн “Ялагчийн шударга ёс” (Victor’s Justice) бус олон улсын шударга ёс хэрэгжих талбар болох ёстой юм. Үүний тулд цэргийн гэмт хэрэг болон хүн ёсны эсрэг гэмт хэрэг зэрэг олон улсын хууль тогтоомж ба үүнд нийцэх Иракийн эрүүгийн хуулийн дагуу зохих шүүх хурлыг хийх хэрэгтэй юм.

Мөн Ирак хүний удирдлагын доор нийтэд ил хуралдаж, болж өгвөл АНУ-ын шууд оролцоог хязгаарлах хэрэгтэй. Цаашлаад дээрх нээлттэй шүүхийн тогтоол шийдвэрийг НҮБ-ын Аюулгүйн зөвлөлд илтгэн батлуулах зэрэг олон улсын шударга хууль ёсоор хүлээн зөвшөөрөгдөх асуудалд ч идэвхтэй арга зам эрэлхийлэх хэрэгтэй.

Хусейны шүүх ажиллагаа нь аль нэг улс орны тэргүүний үйлдсэн бөөнөөр хомрогolon устгах, хүний эрхийг зөрчих, булаан эзлэх, дайн хийх зэрэг олон улсын гэмт хэргийг шүүх 21 дүгээр зууны анхны хуралдаан болж түүхэнд тэмдэглэгдэн үлдэх бололтой. Урьд өмнө Чилийн дарангуйлагч Пиночетыг шүүх гэсэн боловч эцсийн шатанд хүний эрхийг хамгаалах заалтаар шалтгаалан хэрэгжээгүй билээ. Мөн өнөөгийн байдлаар өмнө нь Югославын ерөнхийлөгч асан Мелосевичийг хэрэгт татсан боловч хүнд шийтгэл оноох эсэхийг хэсэг хугацаанд азнасан байдалтай байгаа билээ. Энэ талаас нь авч үзвэл Хусейныг шүүх хурал нь өөрийн ард түмнийг хүчирхийлсэн дарангуйлагчийг олон улс, дэлхий нийт хэрхэн хатуу арга хэмжээ авдгийг харуулах тод жишээ болж үлдэх байхаа.

Гэвч Хусейны шүүх жинхэнэ утгаараа Иракчуудад ач холбогдолтой байхын тулд дарангуйлагчийн харгис харанхуй үеийг халах (өнгөрснийг цэвэрлэх) болон улс

төрийн ардчиллыг үндсээр нь хэрэгжүүлэх эргэлтийн үе болох ёстой. Мөн Ирак хүнд түшиглэсэн өөрөө эрх барих (ард түмний эв нэгдэл)-ийг хэрэгжүүлж, дайнд сүйтгэгдэн хоосорсон Иракийг дэлхий нийтийн хамтын хүчээр дахин сэргээн босгох эхлэлийн цэг болгох хэрэгтэй. Ингэсэн цагт АНУ-ын цэргийн үйл ажиллагаа болон хөндлөнгийн оролцоо зөвтгөгдөж, шударга байж чадах юм.

*Дүгнэлт:*

АНУ болон Иракийн шилжилтийн засгийн газар цаашид нээлттэй шүүх хурлыг шударга явуулж, Хусейныг хатуу яллах хэрэгтэй. Мөн ард түмний эрх ашгийн төлөө шат дараалсан хөтөлбөр гарган шууд хэрэгжүүлж эхлэх хэрэгтэй. Тэгсэн цагт Иракийн асуудлыг шуурхай намдааж, Ойрхи дорнодын энхтайван, аюулгүй байдлыг сэргээж чадах арга зам тавигдана. Энэ явцад АНУ, НҮБ түлхүү оролцон их үүрэг гүйцэтгэхийг ч хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Ялангуяа Иракт байрлаж буй Америкийн цэргийн хүчний хувьд эзэлж авах шинж чанараас татгалзаж, НҮБ-ын удирдлага доорхи энхийг сахиулагч цэргийн үүргээр өөрчлөх нь зүй ёсны асуудал юм.

Мөн АНУ ч олон улсын эрүүгийн шүүхийн дүрэм журмыг хүндэтгэн дагаж, үүнийг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Олон улсын эрүүгийн шүүх нь бөөнөөр хомрогolon устгах гэмт хэрэг, хүний эрхийг зөрчсөн гэмт хэрэг, цэргийн гэмт хэрэг, булаан эзлэх гэмт хэрэг өдөөсөн хувь хүнийг тухайн улс хэрэгт татаж, дотоодод шүүгээгүй, эсвэл тийм бололцоо нөхцөл байхгүй үед тэр хувь хүнийг байцаан шалгаж, зохих шийтгэл ноогдуулдаг байнгын олон улсын шүүх юм.

Гэхдээ АНУ олон улсын шүүх хурал хуралдуулах гэсэн Ромын дүрмийг эсэргүүцсэн 7 улсын нэг юм. Үүний гол шалтгаан нь гадаадад байрлаж байгаа Америкийн цэргийн хүчин олон улсын шүүхээр хэрэгт татагдан, ямар нэг хэмжээгээр ял шийтгэл хүлээх тохиолдолд Америкийн цэргийн сүр хүчинд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй хэмээн эмээснийх юм. Ийнхүү олон улсын шүүхээс татгалзаж байгаа Америкийн энэ эсэргүүцэл нь дотоод, гадаадын хэвлэл, олон түмний шүүмжлэлд өртөж байна. АНУ-ын дотоодын олонхи хэвлэл мэдээлэлд АНУ олон улсын нийгэмлэгт “хуулийн эрх барих удирдлага”-ыг тэргүүлсээр ирсэн ба олон улсын шүүх хуралдааныг дэмжсэнээр цаашид ч тэргүүлэх байр сууриа хадгалж, улам хөгжүүлэх нь АНУ-ын эрх ашигт нийцэх болно хэмээн онцлон тэмдэглэж байна.

Тиймээс өнөөдөр Ирак олон улсын шүүх хуралдуулах Ромын хэлэлцээрийн гишүүн орон биш ч гэсэн Хусейны нээлттэй шүүх НҮБ-ын дүрэмд үндэслэн НҮБ-ын

Аюулгүйн зөвлөл зэрэг шүүхэд татах эрх бүхий тогтоол, олон улсын гэрээ журамд үндэслэн АНУ-ын удирдлага доор Иракийн шилжилтийн засгийн газрын шүүх бус, НҮБ-ын удирдлага доор дэлхий нийтэд ил тод шүүх хуралдааныг хийх нь зүйд нийцэх асуудал юм.

*Найруулж орчуулсан  
Ахлах багш Д.Уламбаяр*

---

Author describes post Saddam's newly formed political, economic situation in Iraq. Article deals with issue of trial of Saddam Hussein at open court and official position of Washington regarding it.